



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.2 дахь заалтын “тахир дутуу болсон” гэснийг “хөдөлмөрийн чадвараа алдсан” гэж, “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, мөн зүйлийн 39.5 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР